



МОНГОЛЫН УЛАМЖЛАЛЫН НЭГДСЭН НАМ
THE MONGOLIAN TRADITIONAL UNITED PARTY

2004 оны 04 дүгээр
сарын 14 ны өдөр

Дугаар 1/51

Улаанбаатар хот

МУНН-ЫН ТЭРГҮҮЛЭГЧИДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Сонгуульд оролцох тухай

МУНН-ын тэргүүлэгчидийн хурлаас ТОГТООХ НЬ:

1. 1992 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр батлагдсан "Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн Хууль"-ийн 19 дүгээр зүйлийг үндэслэн 2004 оны УИХ-ын ээлжит сонгуульд МУНН-ыг оролцуулахаар тогтоосугай.

2. МУНН-ын 2004 оны УИХ-ын сонгуульд оролцох Мөрийн хөтөлбөрийг сайшаасугай.

ДАРГА

ТЭРГҮҮЛЭГЧИД:

Ү.ХҮРЭЛБААТАР

О.ЗАЯА
С.СҮРЭНЖАВ
Л.ХАТАНБААТАР
Л.ЖАРГАЛСАЙХАН
Ц.ХОРЛООБААТАР
Р.ТӨРТӨГТОХ
Ц.БОЛОРМАА
Ц.СҮХБААТАР

АМИБАХ НАМ УАС ТӨРИЙН АМЬДРАЛД ОРОН.
 ЦОХДОО БИМАХЫН БҮРЭН ЭРХ, ТУСГААР ТОГТ.
 НОН, ҮНДЭСНИЙГ ЭВ НЭГДЛИЙГ САХИН ХАМ.
 ГААДАЖ ҮНДЭСНИЙ ХУУЛЬ БОЛОН ТӨРИЙН БУСАД
 ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХҮНДЭЛТЭН БИЕЛҮҮҮЛЖ
 МОНГОЛ ЭХЭ ОРОН, АРД ТҮМНИЙ ЭРХ АДИЙГ
 НИЛЦСЭН ҮЙЛ АЖИЛААГАДА ЯВУУЛАХ ҮҮРЭЛТЭЙ.



Хочу 04 05
 ЧБ
 С.Т.В
 С. Сүрэнжав
 333

БНМАУ-ын Агаарын Зоронд тусгай

сургагчид

1984 оны 01 сарын 14-ийн өдөр 01-р сарын 21-р өдөр

Шонгын галажидын нэгдэл

Нэмэгдсэн бүртгэлд бүртгэж өөрийн дүрэм, мөрийн
 берийнхэн дээр БНМАУ-ын нүүр
 ажлаарыг явуулахыг зөвшөөрөө

ТАМГА

ААРИА

Б. Дорж

ГИШИҮН

С. Сүрэнжав



МУНН-ын тэргүүлэгчдийн
2004 оны 04 сарын 14-ний өдрийн
хурлаас сайшаав.

МОНГОЛЫН УЛАМЖЛАЛЫН НЭГДСЭН НАМЫН
2004 ОНЫ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Нэг. Төрийн байгуулал, ардчилал, шударга ёс:

Төр нь ард түмнийхээ итгэл хүлээж, иргэнээ баталгаатай хамгаалж, улс нийгмээ ардчилсан зарчмаар зохион байгуулж, шударга ёс тогтоох чадвартай, түүнд нийцсэн зохион байгуулалттай байвал улс орон энх амгалан болж хөгжин цэцэглэнэ. Энэ зорилгоор:

1. Төрийн байгуулалтыг төгөлдөржүүлнэ

Бүх ард түмнээр сонгогддог Ерөнхийлөгчийн засаглалтай төр хэрэгтэй гэж үзэж үүний үндсэн дээр Үндсэн хуулийн агуулгыг боловсронгуй болгохыг зорино. Тухайлбал:

1.1. Монгол Улсын төрийн эрх барих дээд байгууллага нь хоёр танхим бүхий парламент байна. Дээд танхим нь нийт ард түмнээс сонгогдоно.

1.2. Хууль тогтоох эрхийг улс төрийн хүчнүүд ард түмнээс хүлээсэн итгэлээр төлөөлөгдсөн байнгын ажиллагаатай 25-30 гишүүнтэй доод танхим эдэлнэ. Доод танхим нь дээд танхимдаа ажлаа хариуцан тайлагнадаг байх бөгөөд дээд танхим нь жилд 1-ээс цөөнгүй удаа 5-7 хоног хуралдаж улс, нийгмийн амин чухал асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

1.3. Засгийн газар болон аймаг, нийслэл, сум, дүүргийн засаг даргын тамгын газруудыг улс төрийн хүчнүүдийн ард түмнээсээ сонгуулиар хүлээсэн итгэлийн харьцаагаар зөвшлийн зарчмаар бүрдүүлж байгуулна. Төрийн аль ч шатанд нэг улс төрийн хүчний ноёрхол тогтоохгүй.

1.4. Шүүх засаглалын нэгдмэл тогтолцоо бүрдүүлж, түүнийг Засгийн газар, хууль тогтоох хурлаас бүх талаар хараат бус нөхцөлд ажиллуулж, хуулийг дээдэлсэн шударга бөгөөд няцашгүй цээрлэлтэй ёсыг сэргээнэ.

1.5. Монгол төр улс үндэстнийхээ язгуур эрх ашгийг дээдэлсэн бодлогын уламжлалыг хадаглана.

2. Ардчилал, шударга ёсны зарчмуудыг бэхжүүлж, хамгаална.

2.1. Монгол Улс дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар хүлээсэн үүргээ чанад биелүүлнэ. Иргэдийн эрх чөлөөнд хууль бусаар халдах, халдашгүй дархан эрхийг хамгаалах эрх зүйн үндсийг хатуу тогтооно.

2.2. Иргэдийн хувийн өмчийн эрхийг хохироож, төр засгийн зохицуулалт, татвар, санхүүгийн бодлогоор хавчих бодлогыг залруулна.

2.3. Олон түмэн улс нийгмийнхээ амьдрал, төр засгийн үйл ажиллагааны талаар үнэн зөв, бүрэн мэдээлэлтэй байх эрхийг баталгаажуулж Үндэсний чөлөөт мэдээллийн тогтолцоонд шилжүүлнэ.

2.4. Төр засгийн байгууллагад ажиллагсадыг улс төр, үзэл бодлоор нь ялгаварладаг гажуудлыг арилгаж төрийн ажлын мэдлэг, зүтгэл, ажиллах чадварыг гол шалгуур болгож, төрийн албыг төвштгөнө.

2.5. Төрийн байгууллагуудад ажиллагсад, түүний дотор өндөр албан тушаалтнуудын хээл хахууль авч, албан тушаалаа хувьдаа ашигласан тухай асуудлыг нягтлан шалгуулж, хууль болон ёс зүйн үнэн бодитой үнэлэлт өгч, нийтэд үнэнээр нь мэдээлж цаашид төрийг хээл хахуулиас хамгаалах найдвартай тогтолцоог бий болгоно.

2.6. Шударга ёсоор хуулийн дагуу шийдвэрлэгдээгүй гэмт хэргийн чанартай асуудлуудыг нэгэн мөр болгож, хохирсон иргэдийн гомдлыг барагдуулахад шүүх засаглалын анхаарлыг төвлөрүүлнэ.

2.7. Улс төрийн харигслалд хэлмэгсэдийн нэр төрийг сэргээж, хохирлыг шударгаар нөхөх асуудлыг төрийн үүрэг гэж үзэж хэрэгжүүлнэ.

2.8. Мал сүрэн төрийн хамгаалалтад байх тухай Үндсэн хуулийн заалт хэрэгжиж нийгэм эдийн засаг, эрх зүйн баталгааг буй болгох бодлогыг баримтлана.

3. Иргэдийн амьдралын баталгааг бүх талаар хангана.

Хүн ардынхаа амьдралын баталгааг хангах нь төрөөс нийгмийн өмнө хүлээх гол үүрэг гэж үзнэ. Энэ үндсэн дээр:

3.1. Асрамж дэмжлэггүй өндөр настан, өнчин ядуу хүүхдийг төрийн хамгаалалтад бүрэн авч тэтгэх баталгаа болгож, үндэсний нийт бүтээгдэхүүний 1-ээс доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгөтэй Төрийн сан байгуулж санхүүгийн шууд дэмжлэг үзүүлнэ.

3.2. Цалин, тэтгэвэрийн доод хэмжээг амьжиргааны өртгийн доод хэмжээнээс багагүйгээр тогтоож үнийн өсөлтийн 1 хувь тутамд 0,8 хувиас доошгүйгээр улирал тутамд нэмэгдүүлнэ.

3.3. Холын бүс нутагт ажиллагсдын цалинг төвийн бүсийнхээс 30 хувь хүртэл нэмэгдэлтэй тогтооно.

3.4. Залуучуудыг гэр бүл болж бие даасан амьдралын гараагаа эхлэхэд нь төрөөс орон сууц барих, орон сууц худалдан авах, бизнес эрхлэх, сурч боловсроход нь удаан хугацааны хөнгөлөлттэй зээл олгоно.

3.5. Төрийн төсвөөс цалинждаг хүмүүсийн цалинг 2 дахинаас доошгүй нэмж, амьдралыг баталгаажуулна.

3.6. Монгол Улсын хөдөлмөрийн чадвартай иргэн бүр хөдөлмөрлөж амь зуулгаа хариуцах үүргийг Үндсэн хуульд оруулж, ажилгүйдлийг хөдөлмөрийн нөөцийн 10 хувь хүртэл бууруулна.

3.7. Олон хүүхэдтэй эхчүүдийн тэтгэврийг нэмэх, өрх толгойлсон эхчүүдэд төрөөс дэмжлэг үзүүлнэ.

3.8. Орон сууцны хувьчлалыг үргэлжлүүлж энэ хувьчлалд хамрагдаагүй гэр хорооллынхонд нөхөн төлбөр хийлгэж хямд өртөгтэй, тохилог хувийн сууц барих төслийг төрөөс ивээн тэтгэж хэрэгжүүлнэ.

4. Эдийн засгийн хөгжлийг нийгмийн хамгааллын баталгаатай уялдуулна

4.1. Аж ахуйн ашиг орлогын татварыг бүхэлд нь 60 хувь бууруулж, бага, дунд үйлдвэрүүдийн бүх татвар, үйл ажиллагааны эхний гурван жилд цэвэр орлогын 10-20 хувиас хэтрэхгүй байхаар тогтооно.

4.2. Зээл, зээлийн хүүгийн бодлогыг мөнгө хүүлэх чиглэлийг эрс өөрчилж үндэсний аж ахуйг тэтгэх бодлого явуулна.

4.3. Малчдын хувийн аж ахуйг зах зээлтэй холбох дэд бүтцийг бий болгож, хөдөө аж ахуйн биржийн салбар, үнэ хаялцуулах худалдааг сумдад зохион байгуулна.

4.4. Монголын малчдын хөгжлийг дэмжсэн улс, нийтийг хамарсан өргөн цараатай хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

4.5. Газар тариалангийн үйлдвэрлэлийн техник, технологийн шинэчлэлийг төрөөс дэмжиж үйлдвэрлэлийг бүрэн сэргээнэ.

4.6. Жижиг, дунд үйлдвэрийг амьдрах чадварын баталгаатай болтол төрөөс дэмжих тогтолцоог бий болгоно.

4.7. Бүс нутгийн цогцолбор эдийн засгийн бие даасан байдлыг бэхжүүлэхэд төрийн эдийн засгийн бодлогыг чиглүүлнэ.

Хоёр. Хүн амын эрүүл мэнд, боловсрол, үндэсний удмын сангийн аюулгүй байдал:

Хүн амын эрүүл мэнд, боловсролыг хөгжүүлж, үндэсний удмын сангийн аюулгүй байдлыг хангах асуудлыг хэтийн бодлоготой шийдвэрлэхэд төрийн бодлогыг чиглүүлэх нь нэн шаардлагатай хүрц асуудал гэж үзнэ. Энэ зорилгоор:

5.1. Хувь хүн өөрийн эрүүл мэндийн хамгаалж, эрүүл аж төрөх соёл эзэмших үйлсийг бүх нийтийн хэрэг болгоно.

5.2. 65-аас дээш насны өтгөс, 16 хүрэлх насны хүүхэд, хөдөлмөрийн чадваргүй хүмүүсийг хэвтэж эмчлүүлэх хугацаа, тоог харгалзахгүй үнэ төлбөргүй эмчилнэ.

5.3. Хөхүүл эмэгтэйчүүдэд хүүхдийг нь 3 нас хүртэл төрөөс тэтгэлэг олгож, эргэж ажилд орох эрхээр хангана.

5.4. Удамшлын өвчин, гажуудлын эсрэг тэмцэх төрийн хөтөлбөр хэрэгжүүлнэ.

5.5. Ерөнхий боловсролын сургалтыг нийгмийн орчин үеийн шаардлагад нийцсэн мэдлэг өгч, мэдлэгийг амьдралд хэрэглэх чадвар олгох хос зорилгод нийцүүлнэ.

5.6. Их, дээд сургуулийг дэлхийн боловсролын чиг хандлагад нийцүүлэн төрийн өмчлөлөөс алгуур гаргаж хувийн өмчийн боловсролын байгууллагыг дэмжих бодлогыг тууштай хэрэгжүүлнэ.

5.7. Соёл, шинжлэх ухаан, боловсролын салбарыг сэргээн хөгжүүлэх төрийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

5.8. Монгол төр хүн ардынхаа сэтгэлийг ариусган, хүмүүнлэг, энэрэнгүй зан суртахууныг төлөвшүүлэхэд уламжлалт шашнаа түшиглэн, түүний шинэчлэлтийг дэмжих нь нийт ард түмний эрх ашиг гэж үзнэ.

Гурав. Үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнол, байгаль орчныг хамгаалах баталгааг бэхжүүлэх тухайд:

Үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнол, байгаль орчныг хамгаалах баталгааг бэхжүүлэх нь орчин цагийн дэлхий нийтийн болон бүс нутгийн нөхцөлтэй үялдүүлэн шийдвэрлэх төрийн бодлогын нэн чухал түлгэмдсэн асуудал гэж үзнэ. Энэ зорилгоор:

6.1. Улс орны аюулгүй байдлын баталгаа нь хоцрогдлыг гэтэлж эрчимтэй хөгжлийн замд тууштай орохтой шууд холбоотой гэж үзнэ.

6.2. Хөрш орнуудтай найрсаг харилцаа, хамтын ажиллагааг эрхлэн хөгжүүлж, Азийн төв бүсийн тогтвортой, аюулгүй байдлын тогтолцоо бий болгоход чиглэсэн алхмууд хийгдэнэ.

6.3. Өндөр хөгжилтэй, хүчирхэг улс гүрнүүдийн байнгын сонирхолыг бий болгож, геополитикийн олон туйлт таатай орчин бүрдүүлэхийг эрхэмлэнэ.

6.4. Монгол Улсын зэвсэгт хүчний бүтэц зохион байгуулалтыг өөрчилж мэргэжлийн цомхон армитай байхын зэрэгцээ бүх нийтээр цэргийн бэлтгэлтэй байж, улс орноо батлан хамгаалах номнолыг баримтлана.

6.5. Монгол Улсын нутаг дэвсгэр дэлхийн шим мандлын олон улсын хамгаалалттай тусгай бүс байх чиг бодлогыг үргэлжлүүлнэ.

6.6. Монгол Улс төвийг сахисан, нээлттэй эдийн засагтай орон байж, бүс нутагтаа олон улсын худалдаа, санхүүгийн төв болохын үндсийг тавина.

6.7. Монгол оронд олон улсын аялал жуулчлалын цогцолбор байгуулах төсөл боловсруулж хэрэгжүүлнэ.

6.8. Улс орны тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг үндэсний хөтөлбөр болгон тодруулан боловсруулж монгол хүний амьдралын чанар нь эрдэм оюуныг дээдлэн, эрүүл энх, амгалан тайван, элбэг хангалуун аж төрөхийн солбилцол дээр тасралтгүй сайжрах үндсийг тавина.